



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 9 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 78.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар 9 гишүүний 100 хувийн саналаар Гантулга овогтой Хатанболдыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.
2. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Хатанболд-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 9 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодыг байгуулж, гишүүдийг томилох тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 81.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн тогтоох нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар дараах 4 хороог баталсугай. Үүнд: Аудитын хороо, Нэр дэвших хороо, Цалин урамшууллын хороо, Мэдээллийн аюулгүй байдлын хороо багтана.
2. Хороодын гишүүдийг дараах байдлаар томилж, даргыг хороод дотроо хэлэлцэн сонгохыг даалгасугай.

Аудитын хороонд доорх 3 гишүүнийг сонгосугай.

- З.Мягмарсүрэн /хараат бус/
- Г.Гантуяа /хараат бус/
- Б.Батцэцэг

Цалин урамшууллын хороонд доорх 3 гишүүнийг сонгосугай.

- Л.Тэмүүлэл /хараат бус/
- Г.Гантуяа /хараат бус/
- Н.Улаанхүү

Нэр дэвшүүлэх хороонд доорх 3 гишүүнийг сонгосугай.

- Л.Тэмүүлэл /хараат бус/
- З.Мягмарсүрэн /хараат бус/
- Э.Эрдэнэжаргал

Мэдээллийн аюулгүй байдлын хорооны гишүүдээр доорх нэр бүхий 3 гишүүнийг сонгосугай.

- А.Баттамир
- Б.Тамир
- Г.Гантуяа /хараат бус/

3. Мэдээллийн аюулгүй байдлын хорооны үйл ажиллагааны журам, чиг үүргийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулан ирүүлэхийг Мэдээллийн аюулгүй байдлын хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД



## АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 9 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

### 2021 оны бизнес төлөвлөгөө боловсруулах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын тэмдэглэлийг үндэслэн тогтоох нь:

1. Модуляр дата төвийг ашиглалтад оруулах төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгахыг Гүйцэтгэх захирал Б.Тамирт даалгасугай.
2. 2021 оны бизнес төлөвлөгөөний эхний хувилбарыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны дотор гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Тамирт даалгасугай.
3. Гүйцэтгэх захирлын гэрээтэй танилцаж, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД